

[www.globeinter.org.mn](http://www.globeinter.org.mn)

[www.journalism-edu.mn](http://www.journalism-edu.mn)

[www.upr-mongolia.mn](http://www.upr-mongolia.mn)

# СЭТГҮҮЛЧДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Гарын авлага

*Глоб Интернэшнл Төвөөс*

*Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй*

*үлдэж буйг таслан зогсоох олон улсын*

*өдөрт зориулан гаргаа*

2015 он

## ГАРЧИГ

1. Олон улсын баталгаа .....	3
2. Үндсэн хуулиар баталгаажсан эрх .....	4
3. Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах асуудлаарх НҮБ-ын тогтоол ба Үйл ажиллагааны төлөвлөгөө .....	5
4. ЮНЕСКО-гийн Ерөнхий захирал Ирина Бокова Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсоох олон улсын өдөрт зориулсан илгээлт .....	10
5. Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсоох олон улсын өдрийг тохиолдуулан толилуулах нь. Үзэл баримтлалын баримт бичиг .....	12
6. Сэтгүүлчдийн аюулгүй байдал та бидэнд яагаад хамаатай вэ? .....	18
7. Ял шийтгэлгүй үлдэх гэж юу вэ? .....	19
8. Сэтгүүлчийн мэргэжлийн эрх .....	22
9. Сэтгүүлчийн ёс зүй .....	25
10. Цагдан хяналт буюу цензур .....	27
11. Сэтгүүлчийн эрхийг хамгаалах механизм .....	32

## 1. ОЛОН УЛСЫН БАТАЛГАА

### Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал

2 дугаар зүйл: Хүн бүр энэ тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлыг ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой.

7 дугаар зүйл: Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчилалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй.

8 дугаар зүйл: Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй.

19 дүгээр зүйл: Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй: энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.

# ARTICLE 19

**"Everyone has the right to freedom  
of opinion and expression;  
this right includes**

**freedom to hold opinions without interference  
and to seek, receive and impart information  
and ideas through any media  
and regardless of frontiers."**

**- Article 19; Universal Declaration of Human Rights**

## **Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пактын 19 дүгээр зүйл:**

1. Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй.

2. Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.

3. Энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага ногдуулна. Тийм ч учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараахь шаардлагаас үүдэн гарсан байх ёстой:

а/ Бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх

б/ Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах.

## **2. ҮНДСЭН ХУУЛИЙН БАТАЛГАА**

14/ ...өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно



### **3. СЭТГҮҮЛЧДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ АСУУДЛААРХ НҮБ-ЫН ТОГТООЛ БА ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

*Товчилсон*

**2013 оны 12 сарын 18-ны өдрийн Ерөнхий Ассамблейн  
68/163 тоот тогтоол**

#### **Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах, тэдний эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буй асуудал**

Ерөнхий Ассамблей нь,

Мэдлэгт суурилсан нийгэм, ардчиллын бүтээн байгуулалт, соёл хоорондын яриа хэлэлцээ, энх тайван, сайн засаглалыг хөхиүлэн дэмжихэд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болоод чөлөөт хэвлэлийн оруулах бодит хувь нэмрийг хүлээн зөвшөөрч,

Сэтгүүлчдийн эрхэлж буй ажлын онцлог тэднийг ихэнх тохиолдолд сүрдүүлэг заналхийлэл, дарамт шахалт, хүчирхийлэлд өртөх онцгой эрсдэлд оруулдагийг мөн хүлээн зөвшөөрч,

... Эмэгтэй сэтгүүлчид ажил үүргээ гүйцэтгэхдээ учирч буй онцгой эрсдэлийг хүлээн зөвшөөрч, үүнтэй холбогдуулж сэтгүүлчдийн аюулгүй байдалд анхаарал хандуулсан арга хэмжээг шийдвэрлэхдээ жендэрийн мэдрэмжтэй хандахын ач холбогдлыг цохон тэмдэглэж,

1. НҮБ-ын Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах, тэдний эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буй асуудлаарх үйл ажиллагааны төлөвлөгөөг талархан тэмдэглэж байна.

2. Эрүүдэн шүүх, хууль бусаар цаазлах, хүчээр сураггүй алга болгох, дур мэдэн баривчлах, мөн зөрчил мөргөлдөөнт, амар тайван нөхцлийн аль алинд буй айлган сүрдүүлэг, дарамт шахалт зэрэг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг үйлдэгдэж буй халдлага, хүчирхийллийн бүх хэлбэрийг эрс буруушааж байна.

3. Арваннэгдүгээр сарын 2-ны өдрийг Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсоох олон улсын өдөр болгохыг шийдвэрлэж байна.

5. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэдний эсрэг үйлдэгдсэн сэжиг бүхий бүх хэлбэрийн хүчирхийллийн хэргийг шүүх эрх мэдлийн хүрээнд үнэн шударга, түргэн шуурхай, үр дүнтэй мөрдөн шалгах, эдгээр төрлийн гэмт хэрэг үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэх, хохирогчдыг шүүхээр хамгаалуулах эрхээр хангах асуудалд хариуцлагатай хандах талаар боломжтой бүхнээ хийхийг Гишүүн орнуудаасаа шаардаж байна.

6. Улс орнуудыг (а) эрх зүйн хэм хэмжээ, (б) шүүх, хууль сахиулах байгууллагын ажилтан, цэрэг, цагдаагийн бие бүрэлдэхүүн, түүнчлэн сэтгүүлчид, иргэний нийгмийн байгууллагынханд сэтгүүлчдийн аюулгүй байдалтай холбоотой олон улсын хүний эрхийн хууль тогтоомж, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн дагуу хүлээсэн үүрэг, амлалтын талаарх ойлголт мэдлэг дээшлүүлэх, (в) сэтгүүлчдэд халдсан хэргийг хянан шинжилж, мэдээлэх, (г) халдлагын хэргийг нийтээр буруушаах болон (д) эдгээр төрлийн халдлагыг мөрдөн шалгаж, шийтгэл ногдуулахад шаардлагатай нөөц бололцоог зориулах замаар сэтгүүлчдэд ажил үүргээ бие даан, хөндлөнгийн оролцоогүйгээр гүйцэтгэхэд нь аюулгүй, таатай орчин бүрдүүлэхийг уриалж байна.

**СЭТГҮҮЛЧДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ,  
ТЭДНИЙ ЭСРЭГ ГЭМТ ҮЙЛДЭЛ ЯЛ ШИЙТГЭЛГҮЙ ҮЛДЭЖ БУЙ  
АСУУДЛААРХ НҮБ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

*Товчилсон*

Сүүлийн жилүүдэд хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд, сэтгүүлчдийн хувийн аюулгүй байдалд халдсан хэрэг, мөн мөрдөх, баривчлах, хорих, мэдээлэл өгөхөөс татгалзах зэргээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжид сөргөөр нөлөөлөх, сэтгүүлчдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгахгүй, эрэн сурвалжлах арга хэмжээ авалгүй орхидог хэргийн тоо санаа зовохуйц хэмжээнд өсөх хандлагатай байна.

ЮНЕСКО болон Сэтгүүлчдийг хамгаалах Хороо (CPJ), Хил хязгааргүй сурвалжлагчид (RSF), Мэдээллийн аюулгүй байдлын олон улсын институт (INSI), Үзэл бодлын чөлөөт илэрхийллийг дэмжин хамгаалах олон улсын сүлжээ (IFEX), Бүх Америкийн хэвлэлийн нийгэмлэг (IAPA) зэрэг бусад байгууллагын цуглуулсан мэдээ баримтад мэргэжлийн үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд, сэтгүүлчдийн талаар айдас төрүүлэхүйц тоо баримт дурдагдах болов.

Түүнээс гадна Үзэл бодлын чөлөөт илэрхийллийг дэмжин хамгаалах олон улсын сүлжээний мэдээлснээр, эдгээр төрлийн арван гэмт хэргийн есд нь гэм буруутай этгээдийг мөрдөн шалгадаггүй. Ял шийтгэлгүй үлдээнэ гэдэг нь хүний эрхийг зөрчсөн этгээдийн асуудлыг шүүхээр шийдвэрлэх арга хэмжээ авалгүй өнгөрөөхийг хэлнэ. Энэ нь сэтгүүлчдэд хүч хэрэглэдэг байдлыг улам гааруулдаг бөгөөд үүний эсрэг шийдвэртэй арга хэмжээ авах шаардлагатай.

Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах, тэдний амийг хороосон этгээдийг ял шийтгэлгүй үлдээхтэй тэмцэх нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлээр баталгаажсан хүний үндсэн эрх болох үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалахад чухал ач холбогдолтой. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хувь хүний эрх ба үүний төлөө хэнийг ч хороох ёсгүй. Энэ нь иргэдийн яриа хэлэлцээ, оролцоог хангаж, ардчиллыг хөхиүлэн дэмжих замаар тэднийг чадавхжуулж, тогтвортой, бие даасан хөгжлийг бүтээгч хамтын эрх.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх, ялангуяа хэвлэлийн эрх чөлөөг боогдуулснаар мэдээлэлтэй, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгэм бүрэлдэн тогтнох аргагүй юм. Сэтгүүлчид аюулгүй орчинд ажиллах нөхцөлд иргэд чанартай үнэн бодит мэдээллийг хялбар олж, үр дүнд нь олон зорилго биелэгдэнэ. Тиймээс, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд, сэтгүүлчдийн амийг хороосон хэргийг мөрдөн шалгахгүй үлдээх нь гэмт этгээдийг зөвхөн ял шийтгэлгүй үлдээгээд зогсохгүй, сэтгүүлч үүргээ биелүүлэх боломжгүй болж, нийгэмд тэдний үзэл бодлоо илэрхийлсэн дуу хоолой үгүйлэгдэж, айлган сүрдүүлдэг, хүч хэрэглэдэг нөхцөл нь өөрийн цензурийг төрүүлж, улмаар хэвлэлийн эрх чөлөө дарамтанд өртөнө.

Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах болон ял шийтгэлгүй үлдээдэг зуршилтай тэмцэхдээ зөвхөн өнгөрсөн явдлын хойноос хөөцөлдөх ёсгүй. Харин сэтгүүлчдэд хүч хэрэглэдэг, тэдний эсрэг хэрэг

ял шийтгэлгүй үлддэг явдлын учир шалтгааныг тодруулахад чиглэсэн арга хэмжээ, урьдчилан сэргийлсэн механизм зайлшгүй шаардлагатай. Энэ нь сөрөг үзэгдэлтэй тэмцэх удирдлагын бүтцийн үр дүнтэй систем байгуулах, зохион байгуулалттай гэмт хэрэг, авлига зэрэг асуудлыг зайлшгүй шийдвэрлэхийг хэлж байгаа юм. Түүнчлэн, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан хуулиудыг (жишээлбэл, гүтгэлгийн тухай хэт хязгаарлагдмал хууль гэх мэт) дахин авч үзэх хэрэгтэй. Хэвлэл мэдээллийн байгууллага нь үйл ажиллагаа явуулдаг нэг салбарын хувьд сэтгүүлчдийн цалин хөлс бага байгаа, мөн тэдний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх ёстойг анхааралдаа авах шаардлагатай. Эдгээр асуудлын талаар болон арга хэмжээ аваагүй тохиолдолд гарч болох хор уршгийн талаар иргэдэд боломжийн хэрээр мэдээлэл хүргэж байх нь зүйтэй юм.

Эмэгтэй сэтгүүлчдэд мөн учрах аюул нэмэгдэж буй нь жендэрийн мэдрэмжтэй хандлага шаардлагтайг илтгэж байна. Эмэгтэй сэтгүүлчид мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцдаа бэлгийн дарамтад өртөх тохиолдол багагүй гардаг ба энэ нь гүйцэтгэсэн ажлынх нь шийтгэл болгож санаатайгаар хүчирхийлэх, нийтийг хамарсан арга хэмжээг сурвалжилж байхдаа олны зүгээс хүчирхийлэлд өртөх, хорих газар эсвэл олзлогдож буй сэтгүүлчид бэлгийн хүчирхийлэлд автах зэрэг олон хэлбэртэй байна. Түүнээс гадна мэргэжлийн болон соёлын гүн гүнзгий хэвшиж тогтсон ойлголтоос үүдэлтэйгээр эдгээр хэргүүдийн ихэнх нь дарагдан өнгөрдөг.

### Зарчмууд

Санал болгож буй үйл ажиллагааны төлөвлөгөө нь дараах зарчмыг удирдлага болгоно. Үүнд:

- Санал нэгдсэн, үр дүнтэй цогц системийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах
- Үр дүнд хүрэх арга барилыг удирдлага болгох, нэн тэргүүнд хийгдэх үйл ажиллагааг тодорхойлох ба үр нөлөөг бүрэн дүүрэн ашиглах
- Хүний эрхэд суурилсан хандлага,
- Жендэрийн мэдрэмжтэй хандлага,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдрэмжтэй хандах,
- НҮБ-ын системээс гадуур стратегийн түншлэл тогтоох, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг сайжруулах асуудлаарх орон нутаг, бүс нутаг, олон улсын төрөл бүрийн байгууллагын санал санаачилгыг дэмжин, ажил хэрэг болгох,

- Ял шийтгэлгүй үлдээх асуудал, сэтгүүлчдэд учирч буй аюулын учир шалтгааныг арилгах үүднээс нөхцөл байдалд тохируулан, асуудалд олон талаас хандах

- НҮБ-аас эрхэмлэдэг үнэт зүйлсийг тусгасан стратеги боловсруулж, судалгааны найдвартай механизм (үзүүлэлт)-аар үр нөлөөг үнэлж, цэгнэн ажиллах

### Зорилт

Дэлхий дахинаа ардчилал, энх тайвныг бэхжүүлэн хөгжүүлэх үүднээс амар тайван болон зөрчил мөргөлдөөнт бүсэд хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд ба сэтгүүлчдэд ажлын чөлөөтэй, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлд үйл ажиллагаа явуулах

Санал болгож буй арга хэмжээ

- НҮБ-ын механизмыг бэхжүүлэх
- Гишүүн орнуудтай хамтран ажиллах
- Бусад байгууллагуудтай түншлэн ажиллах
- Ойлголт мэдлэг дээшлүүлэх
- Аюулгүй байдлыг бэхжүүлэх санал санаачлагыг дэмжих
- Дагалдах арга хэмжээний механизм хэрэгжүүлэх

*Бүрэн эхээр [www.globeinter.org.mn](http://www.globeinter.org.mn)*



United Nations  
Educational, Scientific and  
Cultural Organization

#### **4. ЮНЕСКО-гийн Ерөнхий захирал хатагтай Ирина Бокова Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсоох олон улсын өдөрт зориулсан илгээлт**

2015 оны 11 дүгээр сарын 2

Сэтгүүлчдийн амь насыг хөнөөсөн хэргийн арваас бага хувь нь шийдэгдсэн байна.

Сэтгүүлчдийн эсрэг гэмт хэрэг үйлдэгчдийг ял шийтгэлгүй өнгөрөөж байгаа нь бидний тэмцэл, хамтын үнэт зүйлс, нийтийн зорилгод харшилж байна.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих тусгай эрх бүхий НҮБ-ын төрөлжсөн байгууллагын Ерөнхий захирлын хувьд сэтгүүлчдийн амь насыг хөнөөсөн бүх хэргийг олны өмнө зэмлэн буруушааж, эдгээр хэргийг нягт мөрдөн шалгахыг уриалж байна.

Сүүлийн зургаан жилийн хугацаанд миний бие 540 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан, нийгмийн сүлжээний агуулга бэлтгэгчийн амь насыг хөнөөсөн хэргийг олны өмнө хатуу зэмлэн буруушааж ирлээ.

Сэтгүүлчдийн эсрэг халдлага өсөн нэмэгдсээр байна. Иймээс ЮНЕСКО ял шийтгэлгүй өнгөрөх явдлыг эцэслэх зорилгоор засгийн газрууд, иргэний нийгэм, судалгаа шинжилгээний байгууллага болон хэвлэл мэдээллийнхэнтэй дэлхийн өнцөг булан бүрт хамтран ажилладаг НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд хоорондын хамтын хүчин чармайлтыг хөхиүлэн дэмжих замаар сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах, тэдний эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэх асуудлаарх НҮБ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйлсийг манлайлж байна.

Энэхүү чармайлт үр өгөөжөө өгч байна. Олон улсын түвшинд сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах, тэдний эсрэг үйлдсэн гэмт хэрэг ял шийтгэлгүй өнгөрдөг явдлыг таслан зогсоох асуудлыг хүлээн зөвшөөрөх нь нэмэгдэж байна. НҮБ-ын Ерөнхий Ассамблей, Хүний Эрхийн Зөвлөл болон НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл дээрх асуудал бэрхшээлийг шийдвэрлэхэд чиглэсэн түүхэн тогтоолыг баталсан билээ. Европын

Зөвлөл мөн энэ төрлийн арга хэмжээг бүсийн хэмжээнд хэрэгжүүлж байна. Ял шийтгэлгүй өнгөрөх явдлыг шийдэх зорилгоор шинээр хууль тогтоох, механизм нэвтрүүлж буй улс орны тоо нэмэгдсээр байна. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагууд уг асуудалд анхаарал хандуулах явдал нэмэгдэж байна.

Гэсэн хэдий ч асуудал бэрхшээл ноцтой хэвээрээ. Асар их өөрчлөлтийн энэ цаг үед, нийгэм бүр өөрчлөгдөж буй өнөөгийн нөхцөлд Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд заасан “үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа аргаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх” эрх чөлөөг хангах зорилгоор бид сэтгүүлчдийн эсрэг халдлагыг гэм зэмгүй өнгөрөөх явдлыг таслан зогсоох хүчин чармайлтаа нэмэгдүүлэх шаардлагатай.

Энэ нь үндэсний хууль тогтоомж, олон улсын гэрээнд нийцүүлэн олон нийтийг мэдээлэл авах эрхээр хангаж, үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахыг 16.10 дугаар зүйлээрээ бид бүхнийг уриалсан Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ялаас зайлсхийх боломж олгох бүрт бусад гэмт этгээдүүдийг өөгшүүлж, хүчирхийллийн гаж хэлхээ бий болгодог.

Үүнийг таслан зогсоох ёстой.

Миний бие улс орнуудыг сэтгүүлчдийн эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгаж, хуулийн дагуу зохих шийтгэл хүлээлгэхийн тулд хууль тогтоомж, хамгаалалтын механизмаа ашиглан, зохих шинэ нөөц бололцоогоо дайчлан шаардлагатай арга хэмжээ авахыг уриалж байна.

Миний бие бүх хүмүүст хандан, 11 дүгээр сарын 2-ны өдөр сэтгүүлчид мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцдаа халдлагад өртсөн, амь үрэгдсэн тохиолдолд хуульт ёсны зарчмыг бүрэн баримтлах шаардлага дэвшүүлэхийг уриалж байна.

Үүнд ЮНЕСКО-гийн Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй өнгөрөх явдлыг таслан зогсоох олон улсын өдөрт зориулсан илгээлтийн гол утга оршино.

Ирина Бокова

**5. ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН БАРИМТ БИЧИГ  
СЭТГҮҮЛЧДИЙН ЭСРЭГ ГЭМТ ҮЙЛДЭЛ ЯЛ ШИЙТГЭЛГҮЙ  
ҮЛДЭЖ БУЙГ ТАСЛАН ЗОГСООХ ОЛОН УЛСЫН ӨДРИЙГ  
ТОХИОЛДУУЛАН ТОЛИЛУУЛАХ НЬ**

2015 оны 11 дүгээр сарын 2

Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буй нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба өргөн утгаар нь авч үзвэл хүний эрхийн эсрэг үйлдэж буй харгис хэрцгий гэмт хэргийн мөчлөгт суурилдаг гол хүчин зүйлийн нэг болж байна. Шүүх эрх мэдлийн байгууллагын төлөөлөгчид болох шүүгч, прокурор, хуульч ба цагдаагийн мөрдөн байцаах албаны ажилтнууд бүгд энэхүү ял шийтгэлгүй үлдэж буй үйлдлийг таслан зогсооход чухал үүрэгтэй. Ял шийтгэлгүй өнгөрөөх явдалтай тэмцэхэд үндэсний болон бүс нутаг, олон улсын түвшинд хууль зүйн ухааны туршлагыг хуримтлуулах ба харилцан солилцох нь чухал арга хэрэгсэл байх болно. Олон улсын эрх зүй ба олон улсын хэм хэмжээний талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх нь мөн чухал асуудал юм. Энэ жил ЮНЕСКО ба Европын Хүний Эрхийн Шүүх, Африкийн хүний болон ард түмний эрхийн шүүх ба Коста Рика улсын Сан Хосед төвтэй Америк дундын Хүний эрхийн шүүх хамтран 2015 оны 10 дугаар сарын 9-10 өдрүүдэд Хүндэтгэн дурсах ёслолыг эхлэн тэмдэглэнэ. Мөн 2015 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр Нью Йорк, Амстердам, Лондон, Доха хотноо болон Парис хотноо ЮНЕСКО-гийн Төв байранд стратегийн арга хэмжээ болно.

**СУУРЬ МЭДЭЭЛЭЛ**

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассемблейн 68 дугаар чуулганаас 2013 онд баталсан A/RES/68/163 тогтоолоор жил бүрийн 11 дүгээр сарын 2-ны өдрийг “Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсоох олон улсын өдөр” болгон зарласан билээ. Уг тогтоолоор өнөө цаг үед хэвшин тогтоод буй ял шийтгэлгүй өнгөрдөг явдлыг таслан зогсоохын эсрэг тодорхой арга хэмжээ авахыг гишүүн улс орнуудад хандан уриалсан юм. 2013 оны 11 дүгээр сарын 2-нд Мали улсад хэрцгийгээр хороогдсон Францын хоёр сэтгүүлчийг хүндэтгэн дурсаж энэ өдрийг сонгосон юм. Дээрх тогтоолоор ЮНЕСКО-д энэ Өдрийг манлайлан тэмдэглэх тусгай эрх олгосон билээ. Хэвлэл

мэдээллийн ажилтнууд ба сэтгүүлчдийн эсрэг бүх төрлийн хүчирхийлэл, халдлагыг энэхүү онцгой тогтоолоор эрс буруушаасан юм.

Мөн уг тогтоолоор гишүүн улс орнуудад хандан хэвлэл мэдээллийн ажилтнууд ба сэтгүүлчдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд бололцоотой бүх арга хэмжээ авч, хариуцлага тооцохын тулд тэдний эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шударга шүүхийн өмнө авчрах, хохирсон хүмүүст хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх нөхцөл бүрдүүлэхийг уриалсан. Мөн түүнчлэн, сэтгүүлчдэд мэргэжлийн ажлаа бусдаас хараат бус, аливаа хууль бус, хөндлөнгийн оролцоогүй эрхлэх аюулгүй таатай орчин бүрдүүлэхийг уриалсан юм.

Энэхүү тогтоолоор ял шийтгэлгүй үлдэж буй явдалд онцгой анхаарал хандуулсан нь сүүлийн жилүүдэд олон нийтэд мэдээ, мэдээлэл хүргэхийн төлөө ажиллаж байсан 700 гаруй сэтгүүлч амиа алдсан түгшүүртэй нөхцөл байдлаас үүдэлтэй. Зөвхөн 2012 онд 123 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд ба нийтийн эрх ашгийн төлөө хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүс амь насаа алдсаныг ЮНЕСКО-ийн Ерөнхий Захирал зэмлэн буруушаасан юм. 2013 онд амь үрэгдсэн хүмүүсийн тоо багасч 91 болсон хэдий ч хамгийн олон сэтгүүлч амиа алдсан он жилийн жагсаалтыг удаалж байна.

Зэвсэгт мөргөлдөөний бүс ба тайван нөхцөл байдлын аль алинд нь өдөр тутмын үйл ажиллагаандаа илүү олон сэтгүүлч болон тэдний төрөл төрөгсөд гэмт халдлага, шахалт дарамт, айлган сүрдүүлэг, хууль бусаар хорьж цагдах, хүчээр сураггүй алга болгох, тамлан тарчилгах гэмт үйлдэлд өртөж буй тоо баримтад эдгээр амь үрэгдсэн сэтгүүлчдийн талаарх тоо ороогүй болно. Мөн түүнчлэн, эмэгтэй сэтгүүлчид илүү их эрсдэлд өртөж, тэр дундаа бэлгийн хүчирхийлэлд өртсөөр байна.

Сүүлийн арван жилд амь насаа алдсан сэтгүүлчдийн арван хэргийн зөвхөн нэгд нь ял шийтгэл оноосон байгаа нь өөрийн эрхгүй санаа зовоосон асуудал болоод байна. Ял шийтгэлгүй үлдээж буй нь гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг өөгшүүлж, нөгөө талаас энэ нь нийгэмд, түүний дотор сэтгүүлчдэд “гашуун” нөлөө үзүүлж байна. Ял шийтгэлгүй мултран үлдэх байдал улам даамжирсаар хэм хэмнэл бүхий аймшигт үзэгдэл болон хувирч байна. Төрийн хамгаалалт дутагдаж байгаа учраас олон нийт эрхээ эдлэх аюулгүй нөхцөл бүрдэхгүй байна хэмээн тэд дүгнэж байна.

Сэтгүүлчдийн аюулгүй байдал ба тэдний эсрэг гэмт хэрэг ял шийтгэлгүй үлдэж буй аюулын талаарх ЮНЕСКО-гийн Ерөнхий Захирлын 2014 оны тайланд дурдсанаар, 2006-2013 онуудад бусдын гарт амиа алдсан сэтгүүлчидтэй холбоотой 593 хэргийн дөнгөж зургаа хүрэхгүй хувийг шийдвэрлэсэн байна. Шүүх эрх мэдлийн тогтолцооны янз бүрийн шатанд үргэлжилсээр буй мөрдөн шалгах ажиллагааны баримтаас харахад эдгээр хэргүүдийн дөрөвний нэг нь “шалгаж буй” гэсэн тодотголтой байгаа юм. Ерөнхий Захирал хүсэлт илгээсэн хэдий ч эдгээр хэргүүдээс 60 хувь нь шүүхийн үйл явцын талаарх мэдээлэл огт байхгүй болохыг ЮНЕСКО тодруулсан юм. Мэдээллийн энэхүү хомсдол эдгээр хэргүүдийг мөрдөн шалгах, хяналт тавих шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээллийн сан болоод чадавхид нөлөөлж болох талтай.

Сэтгүүлчид халдсан хэрэг ял шийтгэлгүй үлдэх нь “гутамшигт үнэн” эсвэл “тэрслүү үг”- ийг хүргэдэг сэтгүүлчид аюулд орох ба улмаар тэдний мэдээллийн эх сурвалж болдог жирийн иргэдэд ч “халтай” хэрэг болох нь гэсэн маш сөрөг мэдээлэл нийтэд тарна. Улмаар, хүн бүр, миний эдлэх ёстой эрхийг хамгаалдаг гэж ойлгодог улсынхаа шүүх засаглалд итгэх нийгмийн итгэл үнэмшил үгүй болно. Сонгосон байгаа онилсон ч хууль цаазын өмнө толгой бөхийлгөхгүй үлдэнэ гэдгээ мэдсэнээр сэтгүүлчид ба бусад хүмүүст халдсан гэмт этгээдүүд улам өөгшинө.

2015 оны 5 дугаар сарын 27-ны өдөр баталсан НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 2222 тоот тогтоолоор хүлээн зөвшөөрсний дагуу, “Зэвсэгт мөргөлдөөнтэй бүсэд ажиллаж буй сэтгүүлчид, хэвлэл мэдээлийн ажилтнууд ба энэ салбартай холбоотой боловсон хүчний эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг ял шийтгэлгүй үлдэх нь тэднийг хамгаалахад гол саад бэрхшээл учруулдаг ба тэдний эсрэг гэмт хэрэгт хариуцлага тооцох нь ирээдүйд дахин халдлага үйлдэхээс урьдчилан сэргийлэх гол арга байх болно” гэсэн юм.

Аюулгүйн Зөвлөл уг тогтоолдоо “Олон улсын хуулийн дагуу холбогдох хууль тогтоомжийг сахин мөрдөж, гэмт үйлдэл ял шийтгэлгүй өнгөрөх явдлыг таслан зогсоох ба олон улсын хүмүүнлэгийн хуулийг ноцтой зөрчсөн гэмт этгээдүүдэд хариуцлага хүлээлгэх нь улс орнуудын үүрэг болохыг” мөн онцлон дурдсан юм.

Гэмт этгээд ял шийтгэл хүлээхгүй байснаар нийгэм бүхэлдээ хохирно.

“Дуугүй дараад өнгөрүүлэх мэдээ” гэдэг нь олон нийт зайлшгүй мэдэх ёстой мэдээ гэсэн үг юм. Улс төр, нийгэм, эдийн засгийн гээд аль ч утгаар нь хүмүүс хувийн амьдралдаа зөв зүйтэй шийдвэр гаргахад мэдээлэл амин чухал ач холбогдолтой. Аливаа хүн мэдээлэл олж авах, авсан мэдээлэл чанартай байх нь ардчилал, сайн засаглал ба засаглалын үр дүнтэй бүтэц байгуулахад тулгын чулуу болдог.

Ялангуяа сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйн ийм өргөн хүрээтэй үр дагаврыг хүлээн зөвшөөрснөөр, НҮБ жил бүрийн 11 дүгээр сарын 2-ны өдрийг Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсоох олон улсын өдөр болгон зарласан юм.

Энэхүү олон улсын өдрийг тэмдэглэх болсон нь оролцогч талуудад сэтгүүлчдийн эсрэг гэмт хэрэг ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсооход олон нийтийн анхаарлыг хандуулах стратегийн бололцоог бүрдүүлж өгсөн. Мөн гол ашиг сонирхол нь сэтгүүлчийн аюулгүй байдлаас өөр зүйлд чиглэдэг шийдвэр гаргагчдын анхаарлыг үүнд хандуулахад шинэ боломж нээж өгсөн юм. Үзэл баримтлалын баримт бичгийн гол ач холбогдол нь шударга ёс, гэмт хэрэг ял шийтгэлгүй үлдэж буй явдлыг сэтгүүлчийн ажил үүргийн байдалтай холбогдуулан өргөн утгаар нь авч үзсэнээр хуулийн системийн удирдлагын бүтцэд багтдаг хүмүүстэй хамтран ажиллах бололцоо нээж өгсөнд оршино.

Олон нийтийн оролцоо, гэр бүлийн хүчирхийлэл, авлига зэрэг төрөл бүрийн асуудлаар иргэдийн үг хэлэх эрхийг хамгаалан ажилладаг бусад хүмүүс, олны нүдэн дээр ажил үүргээ гүйцэтгэдэг, ажиллах нөхцөл байдал нь эрсдэлд ороход нийгэмд түгшүүр зарладаг, сэтгүүлчдийн эсрэг гэмт халдлага ял шийтгэлгүй үлдэж буйтай тэмцэхэд чиглэсэн дээрх тогтоолын агуулгыг бүрэн дэмжиж байгаа юм.

Ял шийтгэлгүй өнгөрөөх явдалтай тэмцэх олон улсын өдрийг НҮБ-аас гаргасан Сэтгүүлчдийн аюулгүй байдал ба гэмт хэрэг ял шийтгэлгүй үлддэг асуудалтай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд авч үзэн, НҮБ-ын Удирдлагын Зөвлөлөөс баталж, НҮБ-ын Ерөнхий Ассамблей дэмжин сайшаасан юм.

ЮНЕСКО-гийн төв байранд болсон Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийн бага хурлын 2014 онд гаргасан Парисийн Тунхаглалд: “Сэтгүүлчдийн амийг хороосон хэргийн түвшин тасралтгүй нэмэгдсээр

байгаа нь энэ асуудалд олон улсын байгууллагууд, орон орны засгийн газар, хэвлэл мэдээллийн байгууллага ба бусад хүмүүс ихээхэн анхаарал хандуулж, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх ба тэдний амийг хороосон гэмт этгээдийг шүүхийн өмнө авчрахыг уриалж байна” хэмээн дурдсан юм.

Энэ нь ялангуяа оролцогч бүх талууд өөр хоорондоо хамтын ажиллагаагаа өргөжүүлж, НҮБ-аас гаргасан Үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэхийг уриалсан юм. Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсоох олон улсын өдөр нь НҮБ-ын Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсронгуй болгох томоохон боломж юм.

Энэ жил, ЮНЕСКО энэхүү чухал өдөрт ихээхэн анхаарал тавьсан хэвээр байгаагаа онцлон мэдэгдэхийг зорьж, улмаар хүний эрхийн бүс нутгийн шүүхүүдтэй, тэр дундаа Европын Хүний Эрхийн Шүүх, Африкийн Хүн ба Ард олны Эрхийн Шүүх ба Коста Рика улсын Сан Жосед төвтэй Хүний Эрхийн Америк дундын Шүүхтэй хамтран 2015 оны 10 дугаар сарын 9-10-ны өдрүүдэд хүндэтгэн дурсах болно. Хүний эрхийн бүс нутгийн шүүхүүдтэй хамтарсан стратегийн арга хэмжээг 2015 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр Нью Йорк, Амстердам, Лондон, Доха хотноо болон Парис хотноо ЮНЕСКО-ийн Төв байранд зохион байгуулна.

## ШҮҮХ ЗАСАГЛАЛЫН ҮҮРЭГ БА ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ШҮҮХҮҮД

Сэтгүүлчдийн аюулгүй байдал ба тэдний амь насыг хороосон этгээдүүд ял шийтгэлгүй үлдэхийн эсрэг тэмцэх нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 19 зүйлээр баталгаажсан хүний үндсэн эрх болох үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалахад зайлшгүй чухал юм. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хувь хүний эрх бөгөөд ингэсний төлөө хэний ч амь насыг хороох ёсгүй хэдий ч, энэ нь мөн хүмүүс харилцан ярилцах, оролцох, ардчиллыг хөгжүүлэх замаар хүчирхэгжинэ. Ингэснээр бие даасан тогтвортой хөгжлийг бий болгодог учраас хамт олны эрх юм. Шүүх эрх мэдлийн тогтолцооны бүх төлөөлөгчид ба шүүх засаглалын чанартай оролцоо үүнд зайлшгүй чухал тул хууль, дүрэм, журмыг сайжруулахгүйгээр үүнийг хийх боломжгүй билээ. НҮБ-ын Үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс иш татсан хэрэгжүүлэх стратеги уг

Төлөвлөгөөний хүлээгдэж буй үр дүнг тодорхойлохдоо дээрх зорилгыг маш оновчтой тодорхойлсон юм. Үүнд:

“Сэтгүүлчдийн аюулгүй орчинг бүрдүүлэх, тэр дундаа эрүүгийн шүүхийн сүлжээ ба бусад хууль сахиулагчдын чадавхийг бэхжүүлэх, сайн туршлага солилцохтой холбоотой үйл ажиллагааг дэмжих, сэтгүүлчдийн аюулгүй байдлын механизмыг хөгжүүлэх болоод үндэсний хэмжээнд одоо мөрдөгдөж буй олон улсын хэм хэмжээг хэрэгжүүлэх талаар идэвхтэй ажиллахыг Гишүүн Орнуудад зөвлөсөн юм”.

Үндэсний шүүх эрх мэдлийн тогтолцооны хувьд энэ нь зөвхөн цорын ганц үнэн биш юм. Хүний эрхийн төлөөх олон улсын гурван шүүх бүс нутагтаа хамааралтай Хүний эрхийн Дүрэм ба Конвенцийг хэрэгжүүлэн, мэдээлэл авах эрх ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бэхжүүлэх, түгээн дэлгэрүүлэх замаар сэтгүүлчдийг хамгаалан идэвхтэй ажилладаг. Тэдгээрийн дотор Африкийн Хүний болон ард түмний эрхийн шүүх, Америк дундын Хүний эрхийн шүүх ба Европын хүний эрхийн шүүх багтана.

Эдгээр гурван байгууллагад сэтгүүлчдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэг ял шийтгэлгүй үлдэхтэй тэмцэх талаарх олон сайн хууль дүрэм байдаг бөгөөд энэхүү эрх зүйн туршлага нь үнэхээр ач холбогдолтой, харилцан солилцож, хэлэлцэх нь зүйтэй юм. Олон нийтийн гол эрх ашгийн талаар шүүхүүд хэрхэн түгшүүр зарлаж болохыг дээрх гурвын жишээ харуулж байна.

## ДҮГНЭЛТ

Сэтгүүлчийн эсрэг гэмт халдлага нь мэдээлэл хайж, олж авч буй хүмүүсийн мэдээлэл авах эрхэнд халдаж байгаа учраас энэ нь мөн ардчилал болоод эрх зүйн дүрэм журмын эсрэг буй гэмт хэрэг хэмээн дүгнэж болно.

Мэдээлэл авах эрх ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг түгээн дэлгэрүүлдэг үндэсний болон олон улсын шүүх засаглалын чадавхийг сайжруулах замаар бид энэ нөхцөл байдлыг өөрчилж чадна. Энэ зорилгыг биелүүлэхийн тулд дараах стратегийг боловсруулан мөрдөх шаардлагатай. Үүнд: а) чадавхжуулах; б) түншлэлийн хэлцэл хийх; в) эрх зүйн харьцуулсан судалгаа хийх; г) эрх зүйн мэдлэг, туршлага харилцан


солилцох; д) мөн олон улсын хэм хэмжээний талаарх мэдлэг, туршлага солилцох зэрэг болно.

Үүнээс харахад, улс орнууд ба бүс нутгийн шүүх эрх мэдлийн тогтолцоо, сэтгүүлчид ба эрдэм шинжилгээний байгууллагууд хамтрах замаар тус Олон улсын өдрийг хүндэтгэн дурсах нь албан бус яриа хэлэлцээрийг өргөжүүлэх чухал цаг мөч болж байна. Энэ нь сэтгүүлчдийн хамгаалалтыг сайжруулах стратегийг үр дүнтэй хэрэгжүүлэхийг сурталчлах ба тэдний эсрэг үйлдсэн гэмт хэрэг ял шийтгэлгүй өнгөрдөг явдлыг халахын төлөө тулгамдаж буй гол үүрэг хариуцлагын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх ба үүрэг зорилгоо тодорхойлоход туслах юм.

## **6. СЭТГҮҮЛЧДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ТА БИДЭНД ЯАГААД ХАМААТАЙ ВЭ?**

Сүүлийн арван жилд 600 гаруй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтныг мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцад амийг нь хороосон байдаг. Өөрөөр хэлбэл, долоо хоног бүр дунджаар нэг сэтгүүлч өрнөж буй үйл явдлыг олон нийтэд мэдээлснийхээ төлөө амь насаа алдаж байна. Сэтгүүлчдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийг таслан зогсоох, тэдний эсрэг гэмт хэргийг ял шийтгэлгүй үлдээхтэй тэмцэх зорилгоор НҮБ-ын системийн байгууллагуудын гүйцэтгэх захирлуудын хамтарсан зөвлөл 2012 оны 4 дүгээр сард ЮНЕСКО-гийн санаачлан зохион байгуулсан арга хэмжээний үеэр “Сэтгүүлчдийн аюулгүй байдал болон тэдний эсрэг гэмт хэргийг ял шийтгэлгүй үлдээх асуудлын тухай” НҮБ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.

2013 оны 12 дугаар сарын 18-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 68/163 тоот тогтоолоор жил бүрийн Арваннэгдүгээр сарын 2-ны өдрийг “Сэтгүүлчдийн эсрэг гэмт хэргийг ял шийтгэлгүй үлдээхийг эцэслэх олон улсын өдөр” болгон тэмдэглэхийг шийдвэрлэжээ.





## Яагаад сэтгүүлчдийг дуугүй болгодог вэ?

ЮНЕСКО-гийн Ерөнхий захирал Ирина Бокова сэтгүүлчдийн аюулгүй байдал, тэдний эсрэг гэмт хэргийг ял шийтгэлгүй үлдээхийн аюул заналын талаарх өөрийн илтгэлдээ “Сүүлийн 10 жилийн хугацаанд амь үрэгдсэн 600 гаруй сэтгүүлчдээс гадна илүү олон тооны сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан шархдах, хүчирхийлэлд автах, барьцаалагдах доромжлуулах, айлган сүрдүүлгэд автах, хууль бусаар баривчлуулах гэх мэт халдлагад өртөж байна. Эдгээр төрлийн гэмт хэрэг үйлдэгчдэд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх нь ховор. ЮНЕСКО-гийн авсан мэдээллээр, үйлдэгдсэн хэргийн арваас бага хувьд ял шийтгэл ногдуулсан байна” хэмээн дурдсан байдаг.

Сэтгүүлчид хурцадмал, ээдрээтэй асуудлаар мэдээлэх нь элбэг. Дайн, зэвсэгт мөргөөлдөөнийг сурвалжлах нь хамгийн аюултай. Гэвч ихэнх тохиолдолд сэтгүүлчид дайны халуун цэгт бус авлига, зохион байгуулалттай гэмт хэрэг, хар тамхины наймаа зэрэг орон нутагт өрнөж буй хууль бус үйл ажиллагааг мэдээлснийхээ төлөө төрөлх хотдоо амь насаа алдсан байдаг.

НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын асуудлаарх Тусгай илтгэгч Маргарет Секагьягийн 2012 оны тайланд дурдсанаар, халдлагад өртөх явдал нэмэгдсээр байна. Тэр байтугай байгаль орчны асуудлаар сурвалжлах нь сэтгүүлчдэд амь насаа алдах эрсдэл дагуулдаг.

Өөрөөр хэлбэл, та бидэн шиг жирийн иргэд зайлшгүй мэдэх шаардлагатай үйл явдал, тулгамдсан асуудлыг сурвалжлах явцдаа сэтгүүлчдийн амь насанд аюул учирч байдаг.

НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх газрын мэдээлснээр “гэмт хэрэг авлигыг тэтгэж, бизнес, улс төрийн үйл ажиллагаанд шургалж, хөгжил дэвшилд чөдөр тушаа болж байна. Түүнчлэн өөрсдийгөө хуулиас дээгүүр тавьдаг этгээдүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлснээр засаглалыг хүчийг сулруулдаг.” Чухам дээрх бодит байдалд НҮБ-ын Үзэл бодлын эрх чөлөөний асуудлаарх Тусгай илтгэгч Франк Ла Ру анхаарлаа хандуулж, 2012 оны илтгэлдээ тэмдэглэхдээ, “тухайн орны сэтгүүлчид зэвсэгт мөргөлдөөний хэмжээнд хүртлээ хямраагүй боловч хүчирхийлэл, хууль

ёс алдагдах, дарангуйлал тогтсон нөхцөлд өдөр бүр сорилт бэрхшээлтэй тулгарч байна.”

Сэтгүүлчдийг эрх мэдэлтэй улс төрч эсвэл хар тамхины бүлэглэлийн авлигад холбогдох хэргийг эрэн сурвалжилсны төлөө түүний ойр дотныхон, гэр бүлийн гишүүдийн амь насанд заналхийлэх нь байж болшгүй зүйл юм. Хамгийн хүнд нь, эдгээр заналхийллийн ихэнх нь болж буй үйл явдлыг бидэнд мэдээлдэг хүнийг егүүтгэснээр төгсдөг бөгөөд энэ нь олон нийтийн үнэн бодит мэдээлэл авах эрхийг ноцтойгоор зөрчиж байгаа явдал юм. Сэтгүүлчийн дуу хоолойг боомилох гэсэн оролдлого бүр нь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд халдаж буй хэрэг бөгөөд уг эрх чөлөөгөө эдлэхгүйгээр ардчилсан хүчирхэг нийгэм, сурч боловсрох, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх болоод бизнесийн салбарын ил тод, нээлттэй байдлыг бүрдүүлэгч гол хүчин зүйл юм.

#### **Та ч бас хувь нэмэр оруулж чадна**

ЮНЕСКО дэлхий дахинд сэтгүүлчдийн аюудгүй байдлыг хангах хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн олон боловсон хүчний нөөц бололцоог ашиглан, энэ асуудлаар төрийн бус байгууллагуудтай холбогдох судалгаа, шинжилгээ хийх, ном товхимол гаргахад хамтарч, засгийн газруудтай сэтгүүлчдэд аюулгүй орчин бий болгох асуудлаар хамтарч байна.

ЮНЕСКО нэг бус удаа Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр тэмдэглэх үеэр сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах асуудалд анхаарал хандуулж ирсэн бөгөөд сэтгүүлчдийн амь насыг хороох асуудал хүний амь нас үрэгдсэн зовлон гуниг учруулахаас гадна, нийгэмд, өргөн хүрээнд авч үзвэл, дэлхий нийтэд нөхөгдөж баршгүй хор хөнөөл учруулдаг. Учир нь мэдээлэл авах, үзэл бодлоо иэлрхийлэх эрх бол хүн бүрийн язгуур эрх мөн.

ЮНЕСКО нь 195 гишүүн орны өмнөөс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөө болон мэдээллийн эрх чөлөөний төлөө онцгой үүрэг хүлээсэн НҮБ-ын системийн байгууллага юм. Гэхдээ ЮНЕСКО-гийн дангаар гүйцэтгэх үйл ажиллагаанд хязгаар бий бөгөөд энэ тэмцэлд дэмжлэг туслалцаа шаардлагатай. ЮНЕСКО-гийн үйл ажиллагаанд НҮБ-ын системийн бусад байгууллагууд нэгдэж, НҮБ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хэд хэдэн санаачилга өрнөж

байна. Энэ үйл ажиллагаа хормын зуур тулгамдаж буй асуудлуудыг шийдэхгүй нь мэдээж.

Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах асуудал хүн бүрийн тусламж дэмжлэг, тэр дундаа хэвлэл мэдээллийн байгууллага, иргэний нийгэм, үндэсний эрх бүхий байгууллагын дэмжлэг туслалцааг шаардана. Нэгдсэн хүчин чармайлтаар илүү үр дүнд хүрч болно.

## 7. ЯЛ ШИЙТГЭЛГҮЙ ҮЛДЭЭХ ГЭЖ ЮУ ВЭ?



Impunity “шийтгэлгүй өнгөрөөх, шийтгэлээс чөлөөлөх, торгуулиас зайлсхийх” гэсэн утгатай үг. Олон улсын хүний эрхийн хуулиар, хүний эрхийг зөрчигчдийн хэргийг шүүхээр шийдвэрлэхгүй байх, ингэснээр хохирогчдын эрхийг хуулиар хамгаалах, тэдний нэр төрийг сэргээхээс татгалзах нөхцөл бүрдүүлдэг. Ял шийтгэлгүй үлдээх асуудал ялангуяа хууль ёс сул хэрэгждэг, авлигад идэгдсэн, шүүх засаглал нь сул дорой, аюулгүй байдал хангах хүчнийхэн тусгай эрх мэдэл буюу халдашгүй эрх эдэлдэг тийм улс оронд түгээмэл байдаг.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд 2005 онд өргөн мэдүүлсэн “Ял шийтгэлгүй үлдээх асуудалтай тэмцэх замаар хүний эрхийг хамгаалах зарчим”-д тодорхойлсноор: “гэм буруутныг хариуцлагад татах боломжгүй байх, эрүүгийн, иргэний, захиргааны эсвэл сахилгын шийтгэл хүлээлгэхгүй байх, учир нь эдгээр гэм буруутныг мөрдөн шалгаж, буруутай нь тогтоогдвол тохирох шийтгэл ноогдуулдаггүй, хохирогчдод нь нөхөн төлбөр төлүүлдэггүй.

## 8. СЭТГҮҮЛЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЭРХ

Сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдээс олон нийтэд болон нийгэмд мэдээллийн урсгалыг чиглүүлэх, үүгээрээ дамжуулан төр, засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон харилцаа байдагт оршдог. Эндээс сэтгүүлчийн мэргэжлийн эрх, үүргийн онцлог гарч ирдэг.

Сэтгүүл зүй гэдэг нь "diurnalis" (daily - өдөр тутам) гэсэн латин үгнээс гаралтай. Вэбстерийн мэдээлэл, харилцааны толь бичигт "Сэтгүүл зүй бол мэдээ, мэдээлэл цуглуулах, боловсруулах, нийтлэх, нэвтрүүлэх үйл ажиллагаа юм" гэж тодорхойлсон байдаг. Энэ үйл ажиллагааны гол нөхцөл бол хараат бус, аливаа хэлбэрийн нөлөөллөөс ангид байх явдал. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдийн аль хэр хараат бус байгааг түүний нийгмийн "ноточ нохой байх" үүргээ хэрхэн гүйцэтгэж байгаагаар үнэлдэг. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг төдийгүй хариуцлага юм.



### **Сэтгүүлч гэж хэнийг хэлэх вэ?**

Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооны тодорхойлолтоор "Сэтгүүлч гэж сэтгүүл зүйн үйл ажиллагааг бүтэн буюу хагас цагаар эрхэлж буй хүнийг хэлнэ". Энэ тодорхойлолтоос харахад боловсрол, мэргэжил зэрэг ямар нэг шалгуурыг заагаагүй ч энэ нь сэтгүүл зүйн үйл ажиллагаа явуулах чадвартай (өөрийнх нь ертөнцийг үзэх үзэл, иргэний байр суурь, итгэл үнэмшил, мэдлэг боловсрол, хүмүүжил ёс суртахуунтай г.м), мэргэшсэн байх ёстой гэсэн санааг агуулж байна.

2002 онд хүчин төгөлдөр болсон Эрүүгийн хуульд сэтгүүлчийн эрхийг хамгаалсан заалт орсон нь чухал ач холбогдолтой юм.

*139 дүгээр зүйл. Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх*

*139.1.Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд тараах, эсхүл тараалгахгүй байхын тулд сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучин нэгээс тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.*

*139.2. Энэ хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.*

Сэтгүүлч нь өдөр тутмын мэдээллийг шигшин, ухаалгаар сонголт хийж, шударгаар, хариуцлагатайгаар олон нийтэд хүргэх ёстой.

Олон нийтийн ашиг сонирхол гэж тодорхой мэдээлэл (мэдээ, тайлбар, шүүмжлэлт материал, зураг гэх мэт) мэдэгдлийг олж мэдэх эрх, хэрэгцээ юм.

Олон нийтэд үнэн бодит мэдээллийг шуурхай хүргэх үүргээ ухамсарласан хариуцлагатай сэтгүүлч хараат бус, хүчирхэг байж чадна. Үүний тулд:

- Мэдээлэлтэй байх
- Мэдлэгтэй байх (мэдээлэлтэй мэдлэг- informed knowledge)
- Мэргэжлийн өндөр ур чадвартай байх

### **Мэдээлэлтэй байх**

Сэтгүүлчид мэдээллийн олон сувагтай байдаг. Харин олон эх сурвалжийг судалж, баримт сэлтээ нотолгоожуулан бодитой дүгнэлт хийх нь эргээд сэтгүүлчдэд өмгөөлөлт болно. Мэдээлэлтэй байх, эрх зүйн үндсийг Монгол Улсын Үндсэн хуулийн 16.16, 16.17, Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай ОУ-ын Пактын

19-р зүйлээр баталгаажуулсан. Буруу ташаа, нэг талын өрөөсгөл мэдээлэл сэтгүүлчийг төөрөгдүүлдэг учраас олон эх сурвалжаар баталгаажуулан, нотлох баримтуудыг ямагт цуглуулах хэрэгтэй.



Мэдээллийн ач холбогдол нь:

- Нийгмийн байр сууриа эзлэх, өөртөө итгэлтэй байх, өөрийгөө ойлгох, хөгжүүлэх
- Үнэнийг тунгаан бодох, тодруулан ойлгох
- Эрх, эрх чөлөөгөө зохих ёсоор эдлэх
- Ажил хэргээ зөв баримжаалж, зохион байгуулах, аж байдлаа дээшлүүлэх
- Улс төр, нийгэм, эдийн засгийн үйл явцын талаар тодорхой төсөөлөл ойлголттой байх
- Ардчилсан үйл явцад идэвхтэй оролцох
- Зөв шийдвэр гаргахад нөлөөлөх, ардчилсан, үр ашигтай удирдлагыг төлөвшүүлж, түүнд хувь нэмрээ оруулах
- Төр засгийн үйл ажиллагаанд олон түмэн, иргэний нийгмийн зүгээс хяналт тогтоон хэрэгжүүлэх
- Шударга ёс хийгээд хууль дээдлэх ёсыг сахин хангах
- Эрх тэгш байх боломжоо ашиглах
- Төрийн байгууллага, албан тушаалтнууд эрх мэдлээ хэтрүүлэхээс урьдчилан сэргийлэх

- Аливаа хууль бус явдалтай тэмцэхэд санаачилгатай оролцох үндэс болно.



### **Мэдлэгтэй байх**

Өөрийн олж цуглуулсан мэдээлэл, баримт сэлтийг дэлгэж тавихдаа асуудлын мөн чанар, хор уршиг, нийгмийн үр дагавар болон бусад зүйлийн талаарх олон талт мэдлэгээ зөв зохистой ашиглах нь зүйтэй. Энэ мэдлэг нь өнгөц бус бол үр дүнтэй байх нь

мэдээж. Ул суурьгүй мэдлэг сэтгүүлчийг мэдээлэл, баримтаа буруу зөрүү ашиглах, асуудалд нэг талаас хандан, туйлшрахад хүргэж болзошгүй төдийгүй, улмаар олон нийтийн дунд төөрөгдөл үүсгэж, нийгэмд илүү сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Нийгмийн хурц асуудлыг илчилж, олон нийтэд мэдээлэхдээ цуглуулсан баримтынхаа тодорхой хувийг өөрийн хууль зүйн хамгаалалтад нотлох баримт болгон ашиглахаар хадгалах, түүнийгээ үнэлж чаддаг байх нь чухал.

### **Мэргэжлийн өндөр ур чадвартай байх**

Энэ нь сэтгүүлчид орчин үеийн сэтгүүл зүйн мэдлэг, бүтээлч сэтгэл, авьяас билгээс гадна хариуцлага, ёс зүйн өндөр зарчим баримтлахыг шаардана. Сэтгүүлч мэдээлэл, мэдлэгтэй байхаас гадна мэргэшсэн байвал илүү амжилтад хүрдэг.

## **9. СЭТГҮҮЛЧИЙН ЁС ЗҮЙ**

Сэтгүүл зүй бол ёс зүйн асуудлыг олон талаас нь хамардаг адармаатай мэргэжил юм. Хүн бүрт ёс зүйн өндөр мэдрэмж байдаггүй. Ийм учраас эмч, өмгөөлөгч, сэтгүүлч гээд олон мэргэжлийн хүмүүс ёс зүйн хэм хэмжээг баталж мөрддөг. Энэ бол тухайн мэргэжлийн хүмүүсийн үг дуугүй дагаж мөрдөх зарчмуудын жагсаалт юм. Сэтгүүлчид өөрийн ёс зүйн дүрэм журмыг хэлбэрэлтгүй дагаж мөрдөх шаардлагатай. Ёс зүйн хэмжээ нь сэтгүүлчдийн хараат бус байдлын баталгаа төдийгүй дөрөв дэх эрх мэдлийн тулгуур юм. Ёс зүй нь сэтгүүлчийг ухаалаг, шударга хандахыг шаарддаг. Ёс зүйд үүрэг хариуцлага, хүний мөс, хүн чанар, амьдралын утга учир гэх зэрэг олон асуудал хамаарна.

Ёс зүй нь ёс суртахуун, ёс журмаар тодорхойлогдоно.

- Ёс суртахуун: зан суртахуун, хүмүүжил
- Ёс журам: биеэ авч явах байдал, үйлдэл

Ёс зүй нь албаны болон мэргэжлийн ёс зүй гэсэн хоёр хэлбэртэй байдаг.

### **Албаны ёс зүй:**

Сэтгүүлчийн мэдлэг чадваргүй, сул дорой байдлын улмаас илэрч гарч болох хувийн болон бусад явцуу сонирхлоос хамгаалах хяналтыг тогтоох хэм хэмжээ.

### **Мэргэжлийн ёс зүй:**

Мэдлэг, мэргэжилдээ үнэнч байж, хувийн эрх ашгийг огоорон, мэргэжлийн нэр хүндээ хамгаалж, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлан, үүргээ чанд биелүүлэхийн төлөө тогтоосон хэм хэмжээ.

Сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо болон Монголын Хэвлэлийн зөвлөлөөс 2015 онд баталсан

Сэтгүүлчдийн баримтлах зарчмуудад тусгаж өгсөн байдаг.



### **Сэтгүүлчийн эрх зүйн байдлын гол суурь нь:**

- хараат бус байх зарчим,
- мэдээлэл олж авах, түгээх, мэдээлэлд өөрийн үнэлэмж, дүгнэлт өгөх, өөрийн ба болзолт /зохиомол/ нэрээр нийтлүүлэх эрх,
- мэдээллийн үнэн зөвийг шалгах, түүнийг олж авсан эх сурвалжийн нууцыг хадгалах үүрэг,
- хууль зүй, бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үүрэг
- хувийн тайлбар санаа бодлыг мэргэжлийн үүднээс хариуцах ёс зэрэг болно.

Сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа нь нийгэмд шаардлагатай мэдээллийг олон нийтэд зориулан эрэн сурвалжлах, олж ашиглах, түгээн дэлгэрүүлэх юм. Өөрөөр хэлбэл мэдээллийг цуглуулах, боловсруулах, түгээх гэсэн салшгүй холбоотой эрх, үүргийн нэгдэл мөн.

## 10. ЦАГДАН ХЯНАЛТ БУЮУ ЦЕНЗУР

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус байдалд хамгийн халгаатай зүйл бол цагдан хяналт буюу цензур (censorship) юм.

Цагдан хяналт буюу цензур (латины *senzura* үгээс гаралтай) бол дээрээс доошоо чиглэсэн захиргаадалтын шинжтэй, хүний мэдэх эрхийг ноцтойгоор зөрчиж буй харгис, бурангуй агуулгатай арга хэмжээ юм.

Цензур-цагдан хяналтыг дараах байдлаар ангилж авч үзнэ:

Субъектээр нь:

- төрийн
- редакцийн
- өөрийн

Аргаар нь:

- захиргааны
- эдийн засгийн
- айлган сүрдүүлэх

Үр дагавраар нь:

- урьдчилсан
- дагалдсан



### **Төрийн цагдан хяналт**

Төрийн цагдан хяналт гол төлөв хуулиар дамжин илэрдэг. “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” Монгол Улсын хуулиар мэдээлэлд цагдан хяналт тавихыг хориглож, 3 дугаар зүйлд “Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй” гэж заасан байдаг. Гэвч энэ нь бодит утгаараа хуулиар дамжин хэрэгжиж буй энэ төрлийн цагдан хяналтыг хязгаарлаж чадахгүй байгаа нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийн хэрэгжилтийг хянах механизмгүй байдлаас урган гарч байна.

- Төрийн нууцын хуулийг цагдан хяналт болгон ашиглах
- Нэр төр, гүтгэлэгтэй холбоотой Эрүүгийн хуулийн хатуу чанга заалтыг цагдан хяналт болгон ашиглах

- Сонин хэвлэхгүй байх үүрэг даалгавар өгөх
- ХМХ-ийн эрхлэгч, удирдлагуудыг үндэслэлгүй ажлаас нь халах
- Сонин хэвлэлийн түгээлтийг саатуулах, хязгаарлах
- Өргөн нэвтрүүлгийг зогсоох, саатуулах, хязгаарлах

### **Редакцийн цагдан хяналт**

ХМХ-ийн эзэд, эрхлэгч, редакторууд нь сурвалжлагч, ажилтнуудын өдөр тутмын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох ёсгүй. Үүнийг редакцийн хараат бус байдлыг хангах гэрээ, баримт бичгээр баталгаажуулах ёстой. Энэ бол хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын нэг хэсэг юм.

- ХМХ-ийн эзэд, эрхлэгч, редакторууд сурвалжлагч, ажилтнуудынхаа бичсэн, бэлтгэсэн материалын агуулгыг хянах
- Сурвалжлагч, ажилтнуудынхаа бичсэн, бэлтгэсэн материалыг тодорхой зорилгоор нийтлэхгүй, нэвтрүүлэхгүй байх
- "Болохгүй" гэж үзэж буй хэсгээ хасахыг шаардах
- Цалин хасах, ажлаас халах зэргээр арга хэмжээ авах, шийтгэл ногдуулах
- Элдвээр загнах, хараах зэргээр дарамтлах
- Бусад

Улс төр, санхүүгийн бүлэглэлийн нөлөө хэвлэл мэдээлэлд ихээхэн нэвтэрч байгаа тул хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчийнх нь зүгээс цензур хийх явдал их байна.

### **Өөрийн цагдан хяналт**

Сэтгүүлч өөрийгөө цагдан хянах нь цагдан хяналтын хамгийн ноцтой, хүнд хэлбэр юм. Энэ нь "Сэтгүүлч аливаа аливаа айдаст автан өөрийгөө хянах"-ыг хэлнэ. Энэ нь сэтгүүлч, редакторууд тухайн ХМХ-ийн эзэн, түүний ойрын хүмүүсийн, эсвэл бизнесийн ашиг сонирхлыг хөсөрдүүлэхээс эмээсэндээ тодорхой сэдвийг хөндөхгүй байх, улс төр, эрх баригчдын дарамт шахалтаас айж, тэдний тухай шүүмжлэлт материал нийтлэх, нэвтрүүлэхээс айх зэргээр илэрдэг.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1 хэсэгт хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ, мөн МУ-ын шинэ Иргэний хуулийн 498.1-д "Ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн

үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл /эс үйлдэл/-ээрээ бусдад учруулсан гэм хорын хариуцлагыг түүнийг ажиллуулж байгаа ажил олгогч хүлээнэ” гэж тус тус заасан бөгөөд харин хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрт учирсан хохирлоо Иргэний хуулийн 498.5-д зааснаар уг хуулийн ... 498.1-д заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулна.

- Хууль тогтоомжид нийцээгүй, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрхийг хязгаарласан дүрэм журам гаргах

• Төрийн албан хаагчид элдэв төрлийн дүрэм, журмыг ашиглан дарамт шахалт үзүүлэх (хурал, цуглаанаас хөөх, байгууллагад нэвтрүүлэхгүй байх)

• Сурвалжлагчийн итгэмжлэх үнэмлэх олгохгүй байх, хураан авах

• Зураг авах, бичлэг хийх боломж олгохгүй саатуулах



*self-censorship*

- Нэгэнт олсон мэдээллийн түгээлтэд хяналт тавихыг оролдох
- Монгол Улсын Үндсэн хууль болоод бусад хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, сэтгүүлчдийн эрхийг хязгаарласан бусад үйлдэл байдаг.

### **Эдийн засгийн аргаар цагдан хянах**

“Хэвлэл нь санхүүгийн хувьд биеэ даахгүйгээр, үйл ажиллагааны хувьд бие даасан, хараат бус байж чадахгүй” хэмээн Тэллойрийн тунхаглалд заасан байдаг.

- Өндөр татвар ногдуулах
- Цаас, хэвлэлийн материалыг хил дээр саатуулах

- Их хэмжээний торгууль ногдуулах
- Төрийн мэдлийн байр түрээсэлж буй бол түрээсийн үнийг үндэслэлгүйгээр өсгөх
- Редакцийн эд хогшилд халдах
- Дансыг үндэслэлгүйгээр шалгах, хаах
- Татвар, нийгмийн даатгалын шалгалт байн байн оруулах, ажлыг цалгардуулах
- Бусад


### **Айлган сүрдүүлэх нь**

Сэтгүүлч ажил үүргээ гүйцэтгэж явахдаа янз бүрийн хэлбэрийн хүчирхийлэлд өртдөг. Сэтгүүлчдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх нь ардчилсан төр, засгийн үүрэг бөгөөд чөлөөт хэвлэлийн баталгаа болсон хууль тогтоомж, бүтцийг бий болгож өгөх нь чухал байдаг.

Сэтгүүлчдийн эсрэг хүчирхийлэл нь хатуу цагдан хяналтын нэг хэлбэр юм.

- ХМХ-ийг ялгаварлан гадуурхах (өөрт таалагддаг зарим сэтгүүлчийг эсвэл өөрт ойр буюу өөрийн эзэмшилд байдаг ХМХ-ийг илүү мэдээллээр хангах, засгийн газрын сурталчилгааг зөвхөн тэдгээрт өгөх гэх мэт)
- ХМХ-д хатуу хязгаарлалт тогтоох (сонины цаасны хэмжээнд хязгаарлалт тавих, ХМХ, шууданд онцгой татвар ногдуулах, радио, телевизийн долгионд хязгаарлалт тавих, электрон шуудан, интернэтээр үзэл бодлоо илэрхийлэх боломжийг хязгаарлах гэх мэт)
- Сэтгүүлч, ХМХ-д лиценз, зөвшөөрөл олгохтой холбогдуулан сүрдүүлэх
- Сэтгүүлчдийг мэдээллийн эх сурвалжаа илчлэхийг шаардах, татгалзсаных нь төлөө торгох, шоронгоор айлган сүрдүүлэх
- Төр, засгийн газрын албан тушаалтнууд сэтгүүлчдийг дуудаж, загнах, шаардлага тавих, зааж зааварчлах
- Улс төрч, албан тушаалтнуудын буруу үйлдлийг илчлэн бичсэний төлөө нэр төр, гүтгэлгийн хатуу хууль, зүйл заалтаар далайлган сүрдүүлэх
- Сэтгүүлчийн нэр хүндэд халдах

- Сэтгүүлч, тэдний ойр дотны хүмүүсийн эрүүл мэндэд халдах, амь насанд нь халдахаар заналхийлэх
- Сэтгүүлч, тэдний ойр дотны хүмүүсийн амь насанд нь халдах



### **Урьдчилсан цагдан хяналт**

Урьдчилсан цагдан хяналт бол аливаа мэдээллийн агуулгыг олон нийтэд түгээхээс өмнө хянаж шалгах, үүний үндсэн дээр зөвшөөрөл олгох ажиллагаа юм.

### **Дагалдсан буюу цээрлүүлэх**

Нийтлэл, нэвтрүүлэг олон нийтийн хүртээл болсных нь дараа тэдгээрийг туурвисан, бэлтгэсэн, түгээсэн хүнд захиргааны шийтгэл хүлээлгэх, эд зүйлийг нь хураах, эрх чөлөөг нь хасах зэрэг хариуцлага хүлээлгэх хэлбэрээр илэрч буй бол дагалдсан цагдан хяналтын хэлбэр болно.

Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооны 21-р Их хурлаас баталсан “Ардчилсан хэвлэл мэдээллийн хэрэгслийн соёлын тунхаг”-т ардчилсан нийгэмд мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг онцгой өвөрмөц агаад тухайлсан үүргийг ухаарч сэхээрсэн тэр цагт ардчилал бүрнээ үнэ хүндтэй болох учиртай гэсэн байдаг. Мөн ОУСХ нь хэвлэлийн эрх чөлөө гэдгийг “хөндлөнгийн нөлөөлөл, оролцооноос чөлөөтэй байх явдал мөн” хэмээн тодорхойлсон.

“Хэвлэлийн эрх чөлөөний Харти”-н заалтууд нь чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийг дэмжихэд зайлшгүй зарчмуудыг агуулсан бөгөөд хамгийн өргөн хүрээтэй хүлээн зөвшөөрсөн баримт бичиг юм. Хартийн 1 дэх хэсэгт “Шууд болон шууд бус цагдан хяналтыг (цензур) үл зөвшөөрнө. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээллийг чөлөөтэй цуглуулах, түгээх эрхийг хязгаарласан аливаа хууль, практик үйл ажиллагааг хориглох ёстой. Засгийн газрын, үндэсний болон орон нутгийн эрх мэдэлтнүүд хэвлэмэл болон өргөн нэвтрүүлгийн мэдээллийн хэрэгслийн агуулгад хөндлөнгөөс оролцох, эсвэл мэдээллийн аливаа эх сурвалжид нэвтрэх боломжийг хязгаарлах ёсгүй” гэж заасан байдаг.

## 11. СЭТГҮҮЛЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ МЕХАНИЗМ

Сэтгүүлчийн эрхийг хамгаалах гэдэгт эрхийг зөрчихөөс хамгаалах, урьдчилан сэргийлэхийн тулд төр, түүний эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас эерэг арга хэмжээ авахыг ойлгоно. Эрхийн зөрчил гэж өөрийн иргэдийн өмнө төдийгүй дэлхий нийтийн өмнө хүний эрхийг ямарваа нэгэн ялгаваргүйгээр тэгш эдлүүлэх үүрэг хүлээсэн улс орон буюу бусад этгээд үүргээ үл биелүүлэх явдлыг хэлдэг.

### Үндэсний механизм

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хөндөгдсөн, мэргэжлийн эрх зөрчигдсөн гэж үзэж байгаа бол та эрхээ сэргээн эдлүүлэх боломжийг хангахад зориулагдсан эрх зүйн хэрэгслүүдийг ашиглах нь чухал юм. Монгол Улсын Үндсэн Хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төр... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээнэ ” гэж заасан байдаг. Хүний эрхийг хамгаалах үндсэн чиг үүрэг бүхий байгууллагад Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Шүүх, Хүний Эрхийн Үндэсний Комисс зэрэг байгууллагууд орно. “Монгол Улсын Үндсэн Хуулиар шүүх засаглалын эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллагыг ердийн шүүх, Үндсэн Хуулийн Цэц хоёрт хуваарилан хуульчилсан байна.

Монгол Улсын Үндсэн хууль, Олон Улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төрүүлэх, хууль зүйн туслалцаа авах, шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг мөн хуульчилсан. Үндэсний механизм нь тухай зөрчлийн хүнд хөнгөн, шинж байдлаас хамааран хэд хэдэн загвараар явагддаг.



Үүнд:

1. Өргөдөл гомдол - байгууллагын удирдлага – Шүүх
2. Өргөдөл гомдол – Дээд шатны байгууллага, албан тушаалтан – Захиргааны шүүх – Улсын Дээд Шүүх – Хүний эрхийн Үндэсний Комисс
3. Өргөдөл, гомдол – Анхан шатны Шүүх – Давж заалдах шатны шүүх – Хяналтын шатны шүүх - Хүний эрхийн Үндэсний Комисс

### **Дээд шатны байгууллага албан тушаалтан:**

Эрхээ зөрчигдсөн гэж үзсэн сэтгүүлч нь дээрх загварын алинд нь хамаарах асуудал болохоос хамаарч холбогдох этгээдэд өргөдөл гомдлоо амаар буюу бичгээр гаргана. Өргөдлийг хянан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулдаг төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу асуудлыг шийдвэрлэнэ.

### **Шүүх**

Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх бөгөөд шүүхийг зөвхөн хуулиар байгуулдаг. Шүүх нь сум, сум дундын, дүүргийн, аймаг, нийслэлийн, Улсын дээд Шүүх гэсэн тогтолцоотой. Мөн одоогоор захиргааны дагнасан шүүх байгуулагдан, үйл ажиллагаагаа явуулж байна. Шүүхийн шийдвэр нь эцсийн шийдвэр байдаг бөгөөд хуулийн хүчин төгөлдөр байна.

Шүүгчийн ёс зүйн зөрчил гэж холбогдох хууль болон ёс зүйн дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн санаатай буюу санамсаргүй үйлдэл, эс үйлдлийг хэлнэ. Холбогдох хууль зөрчсөн гэж шүүгчийн хууль зөрчсөн үйлдэл нь эрүүгийн гэмт хэргийн шинжгүй боловч албан үүргээ гүйцэтгэж байхдаа хуульд заасан үүрэгт ажлаа зориуд эсхүл хайнга хандаж гүйцэтгэхгүй байх /эс үйлдэл/, эсхүл эрх мэдлээ урвуулах буюу хэтрүүлэн хууль бус шийдвэр гаргах /үйлдэл/, нөгөө талаас шүүгч иргэний хувьд бүх хуулийг биелүүлэх үүрэгтэй ба хуулийг санаатай болон болгоомжгүйгээр зөрчихдөө шүүх, шүүгчийн нэр хүндийг ашигласан, унагасан, харш үйлдэл хийсэн байхыг ойлгоно.

### **Хүний Эрхийн Үндэсний Комисс**

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хууль нь 2001 оны 12-р сард батлагдсан бөгөөд Комисс нь Монгол Улсын

Үндсэн Хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаарх гомдол хүлээн авч шийдвэрлэдэг. Комисст гомдол гаргах эрхийг Монгол Улсын Үндсэн Хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөг нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн зөрчсөн гэж үзвэл Монгол Улсын иргэн дангаар буюу хамтарч, Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харъяалалгүй хүн эдэлдэг. Хуулиар гомдолд дараах шаардлага тавьдаг. Үүнд:

1. Гомдол гаргагч гомдлоо захиргааны журмаар шийдвэрлүүлсэн байх.
2. Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан ямар эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн болохыг заах.
3. Гомдол гаргагч өөрийн нэр, оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж, гарын үсгээ зурсан байх.
4. Гомдолд холбогдож байгаа аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүний нэр, хаяг, утасны дугаар холбогдох бусад баримтыг хавсаргасан байх.

Мөн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд байгаа болон хянан шийдвэрлэгдсэн эрүү, иргэний хэрэг, маргааны талаарх гомдлыг хүлээн авахгүй бөгөөд Комиссын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлага, зөвлөмж гаргадаг байна.

### **Тусгай шат:**

Үндсэн хуулийн Цэцэд хандах

Цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих үүрэгтэй. Та Үндсэн хуульд тусгайлан заасан байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааг Үндсэн хууль зөрчлөө гэж үзвэл өргөдөл, мэдээлэл, хүсэлтээ Цэцэд хандан гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Цэц нь ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний болон Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар СЕХ-ны гаргасан шийдвэр Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэж, дүгнэлт гаргана. Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн авч шийдвэрлэн,

тогтоол гаргана. Улсын Их Хурал дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй үндэслэл зөв болох нь нотлогдвол өмнөх дүгнэлтээ хүчингүй болгох, хэрэв үндэслэл нь батлагдахгүй бол Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгож тогтоол гаргана.

### **Олон Улсын механизм**

Олон Улсын механизмыг бүсийн болон дэлхийн гэж ангилж болно. НҮБ-ын дүрмэнд “Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдал нь НҮБ-ын өмнөө тавьсан зорилго, чиг үүргийн цөм нь бөгөөд НҮБ-ын дүрмийн гол зорилтын нэг мөн” хэмээжээ. Олон Улсын механизм нь эхлээд дотоодын арга хэрэгслүүдийг дуусгасан байх ёстой. Хүний эрх болон үндсэн эрх чөлөөг хэрцгий балмадаар зөрчсөн маргааныг НҮБ-ийн Эдийн засаг нийгмийн зөвлөлөөс 1970 оны 5 сарын 27-ны өдөр 1503 тогтоолоор батлан гаргасан 1503 дугаар журмын дагуу шийдвэрлэдэг. Хянаж үзэх мэдээлэл нь дараах шалгуурыг хангасан байна:

- o Ямар нэгэн улс төрийн санаа зорилго агуулаагүй байх
- o Эрх, эрх чөлөөг зөрчсөн нь баталгаатай гэрчлэгдсэн
- o Хүний эрхийн талаар шууд болон найдвартай мэдэж байгаа эсхүл зөрчлийн улмаас хохирсон гэгдэж гомдол гаргаж байгаа хувь хүн болон бүлэг хүмүүсээс ирүүлсэн байх
- o Эрхийг зөрчсөн зорилго, бодит байдлуудын талаар тодорхойлох
- o Үндэсний хэмжээн дэх шийдвэрлэлт үр дүнгүй, эсхүл удаан хугацаагаар шалтгаангүйгээр удаашруулна гэдгийг үнэмшилтэйгээр хариулснаас бусад тохиолдолд дотоодын бүхий л арга хэрэгслүүдийг ашиглаж дуусгасан байх

### **НҮБ болон Олон улсын бусад хүний эрхийн байгууллагад хандах**

Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протоколын 3 дугаар зүйлд зааснаар энэхүү протоколын дагуу ирүүлсэн нэргүй, эсхүл Хорооны үзэж байгаагаар тийнхүү мэдээлэх эрхээ буруугаар ашигласан буюу Пактын заалтуудтай нийцээгүйгээс бусад гомдлыг Хүний Эрхийн Хороо хүлээн авч хэлэлцэнэ. Аливаа мэдээллийг Пактын аль нэг заалтыг зөрчсөн гэгдэж буй улсын сонорт

хүргэнэ. Мэдээлэл хүлээн авсан улс тухайн асуудал болон түүнтэй холбогдуулж ямарваа арга хэмжээ авсан бол, тэр тухай тайлбар буюу мэдэгдэл бичгээр гаргаж зургаан сарын дотор Хороонд ирүүлнэ. Хороо Протоколын дагуу ирүүлсэн мэдээллийг авч хэлэлцэхдээ хувь хүн болон холбогдох улсаас бичгээр ирүүлсэн бүхий л мэдээллийг харгалзана. Ийнхүү хийсэн ажлынхаа товч тайланг Хороо жил бүрийн илтгэлдээ тусгаж, улс орнуудад шаардлага тавина.

### **Сэтгүүлч өөрийгөө өмгөөлөх нь**

Шvvмжлэлтэй, хурц нийтлэл хэвлэгдэхэд тvvний дагуу тодорхой хvmvvc, байгууллага нэхэмжлэл гаргана. Тиймээс сэтгvvлч өөрийн бичсэн нийтлэлийн талаарх бvх баримт, нотолгоог бvрдvvлж, гаргаж тавих ёстой.

ИХШХШХуулийн, Нотлох баримт гаргах ба цуглуулах, бүрдүүлэх, 38 дугаар зүйл

38.3. Шүүх зохигч аль нэг талын хүсэлтээр эсрэг талаас нотлох баримтыг албадан гаргуулж болно.

38.4. Хэргийн оролцогч хуурамч нотлох баримт гаргах буюу түүнийг хууль бус аргаар цуглуулахыг хориглоно.

38.5. Нотлох баримтыг гаргах, цуглуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол тэдгээр нь нотлох чадвараа алдах бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.

38.6. Хэргийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримт нь төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой; түүнчлэн туршилт, үзлэг, таньж олуулах, шинжилгээ хийлгэх, гэрчийн мэдүүлэг авах тохиолдолд нотлох баримтыг хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүх бүрдүүлнэ.

38.7. Нотлох баримтыг анхан шатны шүүх хуралдаан эхлэхийн өмнө гаргаж өгнө.

### **Нотлох баримтыг хамгаалах**

50.1. Хэрэг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай нотлох баримтыг өөрчлөх, устгах, бусдад шилжүүлэх, нуун дарагдуулах зэргээр уг хэргийг хянан шийдвэрлэхэд саад учруулж болох үндэслэлтэй гэж үзвэл хэргийн оролцогч уг нотлох баримтыг хамгаалуулахаар хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүхэд хүсэлт гаргаж болно.

50.2.Хүсэлтэд ямар нотлох баримтыг хамгаалах, хэргийн ямар байдлыг батлахад ач холбогдолтой болон хамгаалах болсон шалтгааныг заана.

50.3.Шүүгч уг хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл нотлох баримтыг хамгаалах тухай, хэрэв үндэслэлгүй гэж үзвэл татгалзах тухай захирамж гаргана.

## **БАРИМТ, БАРИМТ, БАС БАРИМТ**

Нотлох баримт бичиг, дууны болон дүрс бичлэгт хадгалсан гэрчийн яриа, бусад баримт сэлтийг архивлан хадгалах

1. Тэмдэглэл хөтлөх
2. Аудио бичлэг хийх
3. Видео бичлэг хийх
4. Фото зураг авах
5. Хуулбарлаж авах. Энэ тохиолдолд аль болох хуулбарын тамга даруулах

### **Мэдээлэл цуглуулахдаа...**

Мэдээлэл өгсөн хүнээсээ ярилцлагыг диктофон, гар бичмэл болон аль ч хэлбэрээр авсан тэр хүнээрээ гарын үсэг зуруулж баталгаажуулах хэрэгтэй.

Гэрч мэдээллээсээ буцах, худалдагдах тохиолдол их байдаг.

Хэрэв сэтгүүлчид тийм гарын үсэгтэй ярилцлага байгаад, харин нөгөө хvн нь ярилцлагандаа худлаа зvйл хэлсэн байх юм бол тэр хvн өөрөө шvvхийн өмнө хариуцагчаар татагдана. Сэтгүүлч өөрийн мэргэжлийн ёс журмын дагуу материал олж авсан бол тvvнийгээ хаанаас, ямар замаар олж авснаа заавал тайлбарлах ёсгvй. Энэ нь сэтгүүлчийн ёс зvйд хамааралтай, ерөнхий журмаар тогтоогдсон зvйл. Харин ганцхан шvvгч vvнийг асууж, хаанаас олж авсныг нь тогтоох эрхтэй.



### **Хамгаалах аргууд**

- o Хэвлэгдэхээс нь өмнө нийтлэлээ авчирч үзүүлэн зөвлөгөө авсан байх
- o Өөрсдөө хичнээн хугацаа өнгөрсөн ч бичсэн зүйлийнхээ үндэслэлийг нотлох баримтаа хаяж үрэгдүүлэхгүй, хадгалж байх
- o Ямар бичиг баримтыг хадгалах вэ? Үүнд хамгийн түрүүнд танай шүүгч нар нотлох баримтын хувьд юуг хүлээн зөвшөөрдөг вэ гэдгийг анхаарах хэрэгтэй. Жишээлбэл: аливаа мэдээллийг агуулсан албан ёсны бичиг баримт - нотолгоожуулсан ярилцлага гэх мэт